



Зөвлөмжийн Цуврал

ЗЦ92-1

Нэмэлт, өөрчлөлт 1 (1)

**Аюултай барааны сургалтын
хөтөлбөрүүд**

2021 оны 6 сарын 8

Ерөнхий

Иргэний нисэхийн ерөнхий газрын Зөвлөмжийн цуврал (ЗЦ) нь холбогдох дүрмийн шаардлагыг хангаж байгааг Дарга хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр илэрхийлсэн стандарт, туршлага, журмыг агуулсан байдаг.

Хүлээн зөвшөөрөхүйц хэлбэр нь Даргад дүрмийн шаардлагыг хангаж байгааг нотлох цорын ганц хэлбэр биш юм. Хүлээн зөвшөөрөхүйц шинэ стандарт, туршлага, эсхүл журам гарч ирсэн тохиолдолд холбогдох ЗЦ-д нэмж оруулах болно.

Түүнчлэн, энэхүү ЗЦ нь дүрмийн шаардлагыг хангах зааварчилгаа материалыг агуулсан болно. Зааварчилгаа материал нь хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрт тооцогдохгүй.

Зорилго

Энэхүү ЗЦ нь ИНД-92-ын шаардлагыг хангасан сургалтын хөтөлбөрийг боловсруулах аргачлалаар хангахад оршино.

Хамааралтай дүрмүүд

Энэхүү ЗЦ нь ИНД-92-ийн Е Бүлэг “Сургалт”-т шууд хамаарна.

Өөрчлөлтийн тэмдэглэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

ЗЦ92-1-ийг монгол болон англи хэл дээр боловсруулсан бөгөөд хэрэв эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална.

ЗЦ92-1-ийг NZ AC92-1-ийн 2007 оны 04 сарын 27-ны өөрчлөлт 1-д үндэслэн боловсруулсан болно.

Өмнөх үг

ИНД-92 нь аюултай барааг агаараар аюулгүй тээвэрлэх эрх зүйн зохицуулалт юм.

Аюултай барааг агаараар тээвэрлэхэд оролцдог хүн бүр энэхүү үйл ажиллагаатай холбоотой эрсдлийг бууруулах үүднээс дүрмийн шаардлагыг чанд мөрдөх үүрэгтэй. Хэрэв сургалтыг хийхгүй бол агаарын тээврийн салбарт гарч байсан гашуун туршлага, харамсалтай үр дагаварт хүрч болзошгүй.

Аюултай бараанд хамаарах зарим эд зүйл болон бодис нь үлэмж шатамхай, хортой, тэсрэмтгий болон идэмхий шинж чанартай байдаг. Эдгээр зүйлийг зохих маягаар таньж, баглаж боож ачаалаагүй тохиолдолд, агаарын хөлөг, түүгээр зорчин явагчдыг өмнө нь нэг бус удаа гарч байсан эмгэнэлтэй үр нөлөөнд хүргэх аюулд оруулах хор нөлөөтэй.

Зохих ёсоор төлөвлөж, бэлтгэсэн сургалтын хөтөлбөр нь аюултай барааг агаараар тээвэрлэх явцад агаарын хөлөг, түүний бүхээгт байгаа зорчигчдод аюул учруулахгүй гэдгийг бататгах чухал арга хэрэгсэл юм.

Гарчиг

Ерөнхий.....	1
Зорилго.....	1
Хамааралтай дүрмүүд.....	1
Өөрчлөлтийн тэмдэглэл.....	1
Өмнөх үг.....	2
1. Ерөнхий зүйл.....	4
1.1 Сургалтын хөтөлбөрийг боловсруулах.....	4
1.2 Сургалтыг баталгаажуулах.....	4
1.3 Сургалтад хамрагдах шаардлагатай ажилтнууд.....	4
1.4 Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны аюултай барааны дүрэм.....	5
1.5 Сургалтын гарын авлага.....	5
2. Сургалтын хөтөлбөр.....	6
2.1 Багшид тавигдах шаардлага.....	6
2.2 Хөтөлбөрийн сэдэв.....	6
2.3 Сургалтын зорилго.....	6
2.4 Сургалтын арга.....	7
2.5 Сургалтын хөтөлбөр.....	8
3. Давтан сургалт.....	13
4. Аюултай барааны сургалтад хамрагдсан баталгаа.....	14
5. Сургалтын бүртгэл.....	14

1. Ерөнхий зүйл

1.1 Сургалтын хөтөлбөрийг боловсруулах

Дараах этгээд ИНД-119–ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч, эсхүл гэрчилгээ эзэмшигчийн үйлчилгээний агентын аюултай бараатай холбоотой үүрэг гүйцэтгэхээр томилогдсон ажилтны аюултай барааны сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургалтыг зохион байгуулна:

- a) ИНД-119-ийн гэрчилгээ эзэмшигч бөгөөд аюултай барааны сургалт явуулах зөвшөөрөлтэй байгууллага; эсхүл
- b) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч.

Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчээс, эсхүл гэрчилгээ эзэмшигчийн үйлчилгээний агентаас бусад байгууллагын аюултай бараатай холбоотой үүрэг гүйцэтгэхээр томилогдсон ажилтанд дараах этгээд сургалт зохион байгуулна:

- a) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч; эсхүл
- b) олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны аюултай барааны сургалтын хөтөлбөрийн хүчинтэй итгэмжлэлтэй.

1.2 Сургалтыг баталгаажуулах

ИНД-119, эсхүл ИНД-141-ийн дагуу олгосон гэрчилгээ эзэмшигч, эсхүл хүсэлт гаргагч нь аюултай барааны сургалтыг зохион байгуулахдаа дараах дэлгэрэнгүй мэдээллийг хүлээн зөвшөөрүүлснээр сургалт явуулах эрхтэй болно:

- сургалтын хөтөлбөр
- сургалтын хөтөлбөрийн сэдэв, агуулга
- багш зааварлагчийн дадлага туршлага, мэргэжил

Тухайн байгууллага сургалтаа тодорхой заасан хөтөлбөрөөр хязгаарлаж болох ба олгосон гэрчилгээнд энэ талаар тусгасан байна.

1.3 Сургалтад хамрагдах шаардлагатай ажилтнууд

- Аюултай барааг тогтмол илгээгч болон түүний үйлчилгээний агент
- үйл ажиллагаа эрхлэгч
- аюултай барааг агаараар тээвэрлэхээр хүлээн авах үйлчилгээний агент
- үйл ажиллагаа эрхлэгчээс бусад, зорчигч, эсхүл ачааг агаараар тээвэрлэх, эсхүл бэлтгэх ажиллагаанд оролцдог байгууллага болон этгээд
- зорчигч болон түүний тээшинд аюулгүйн үзлэг хийдэг байгууллага

Аюултай барааны сургалтын хөтөлбөрийг амжилттай дүүргэсэн этгээд нь давтан сургалтанд хоёр жил тутамд хамрагдах ёстой.

1.4 Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны аюултай барааны дүрэм

Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны аюултай барааны дүрэм нь түүний гишүүн агаарын тээвэрлэгчдийн боловсруулсан зарим нэмэлт шаардлага бүхий ICAO-гийн техникийн зааварчилгааны хувилбар юм. Тодруулбал, олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны дүрэм нь түүний гишүүн агаарын тээвэрлэгчид болон олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбоо интерлайн гэрээгээр ачаа хүлээн авах талуудын хооронд байгуулах ачаа илгээгчийн мэдүүлэг бүхий аюултай барааны баримт бичгийн шаардлагыг тодорхой зааж өгдөг.

Ихэнх агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчид аюултай бараатай харьцах өдөр тутмын үйл ажиллагаандаа олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны аюултай барааны дүрмийг мөрддөг ба аюултай барааны сургалтад эдгээр нь багтсан байдаг. Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны аюултай барааны дүрмийн дагуу сургалт зохион байгуулахыг хүлээн зөвшөөрөх боловч агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч болон тогтмол илгээгч нь сургалтын хөтөлбөрт Техникийн зааварчилгааны шаардлага тусгагдсан байгааг нягтлах нь зүйтэй.

1.5 Сургалтын гарын авлага

Чикагогийн конвенцийн Хавсралт 18-ын шаардлагыг хангах, олон улсын жишиг түвшинд мэргэжлийн бэлтгэлийг хангах зорилгоор ICAO, олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооноос хамтран сургалтын баримт бичгийг боловсруулсан. Тэдгээр нь аюултай барааг агаараар тээвэрлэх бүх сэдвийг хамарсан байх бөгөөд ялангуяа сургалтын хөтөлбөрийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой, аюултай барааг тээвэрлэх үйл ажиллагаанд оролцдог тодорхой ангиллын ажилтан бүрд бие даан суралцахад зориулсан гарын авлага дөрвөн ширхэг ном юм. Үүнд:

Ном 1:	Илгээгч, ачаа тээвэр зуучийн байгууллагууд болон агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн ачаа хүлээн авах ажилтнууд
Ном 2:	Ачаалал төвлөрөлтийн ажилтнууд болон нисэх баг
Ном 3:	Зорчигч үйлчилгээний ажилтан болон бүхээгийн ажилтан
Ном 4:	Ачигч нар ба ачаа хадгалах байгууламжийн ажилтнууд

2. Сургалтын хөтөлбөр

2.1 Багшид тавигдах шаардлага

Аюултай барааны сургалт зохион байгуулах багш нь дараах шаардлагыг хангасан байна:

- a) наад зах нь ачаа хүлээн авах ажилтны аюултай барааны сургалтыг амжилттай дүүргэсэн байх;
- b) заах ур чадварын сургалтад амжилттай хамрагдсан байх;
- c) тухайн сургалтыг явуулах мэргэжлийн дадлага туршлагатай байх; эсхүл
- d) олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны аюултай барааны сургалт явуулах хүчинтэй магадлан итгэмжлэлтэй байх.

2.2 Хөтөлбөрийн сэдэв

Сургалтын хөтөлбөрт дараах зүйлийг тусгасан байна:

- сургалтын судлагдахуун
- сургалтын агуулгын нарийвчилсан тодорхойлолт
- сургалт явуулах аргачлал
- сургалтад хэрэглэгдэх хангалт төхөөрөмж
- суралцагчийн мэдлэг, чадвар, ажлын байранд тэнцэх зэргийг тодорхойлох арга зүй.

2.3 Сургалтын зорилго

Сургалтанд хамрагдаж амжилттай төгсөгч нь дараах судлагдахууны тухай мэдлэг чадварыг эзэмшсэн байвал зохино. Эдгээр эзэмшвэл зохих мэдлэг нь ерөнхий шинжтэй ба суралцагчийн гүйцэтгэх ажил үүрэгтэй уялдсан байх шаардлагатай:

- эрх зүйн зохицуулалт ба ажилтны үүрэг хариуцлагын тухай ойлголт
- тээвэрлэхийг хориглосон бодис, эд зүйл, эсхүл тэдгээрийг тээвэрлэхэд тавигддаг хязгаарлалтын тухай ойлголт
- бодис болон эд зүйлийг аюултай шинж чанараар нь таньж мэдэх, тээвэрлэлтэд хүлээн авч болохуйц нөхцөлийн тухай ойлголт
- аюултай барааны жагсаалтад багтдаг ачаанд тавигдах шаардлагын тухай мэдэгдэхүүн
- “Техникийн зааварчилгаа”-нд мэдүүлсэн зөрүүний тухай мэдлэг

- баглаа боодол хэрхэн хийх тухай болон савлалтын багцын тухай мэдлэг
- баглаа боодлын чанар, тэдгээрийн сорилт шалгалт, таних тэмдэг тавих тухай ойлголт
- □□□□Баглаа боодолд тэмдэг тавих, шошго зүүх ажиллагаатай холбоотой шаардлагын тухай ойлголт
- тээвэрлэлтийн баримт бичигт тусгагдах ёстой мэдээлэл
- аюултай бараа хүлээн авах, илгээх арга ажиллагаа ба хяналтын хуудсыг хэрэглэх тухай
- аюултай барааг шалган нягтлах шаардлагатай нөхцөл байдлыг таньж мэдэх ба бохирдлыг арилгах чадвар
- аюултай барааны ачаалалтын зааврыг дагаж мөрдөх ба биелүүлэх чадвар
- аюултай бараатай холбоотой ямар мэдээлэл солилцох тухай
- аюултай бараатай холбоотойгоор гарсан осол зөрчлийг мэдээлэхэд
- тавигдах шаардлагын тухай ойлголт.

2.4 Сургалтын арга

Сургалтыг бие даан суралцах, танхимын сургалт, видео болон онлайн сургалт, эсхүл эдгээрийн хосолсон төрөл бүрийн аргаар явуулж болно. Тухайн сургалтыг суралцагч нэг бүр өөрийн үүрэг хариуцлагатай уялдсан мэдлэг чадвараа илтгэн харуулах бололцоогоор хангагдсан анги танхимд явуулах нь зүйтэй.

2.5 Сургалтын хөтөлбөр

Дараах сургалтын үндсэн хөтөлбөрийн дагуу холбогдох ажилтнуудад сургалт явуулах нь зүйтэй. Сургалтын хөтөлбөр нь эдгээрээр хязгаарлагдахгүй ба хөтөлбөр бүрийг тухайн бүлгийн ажил үүргийн шаардлагад нийцүүлэн боловсруулах хэрэгтэй.

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР 1 – Ачаа хүлээн авах ажилтан, агаарын хөлгийн диспатчер

- a) Ерөнхий мэдээлэл болон сургалтын танилцуулга
- b) Монгол Улсын хууль, дүрэм
- c) Олон улсын зөвлөмж
 - ICAO-гийн Техникийн зааварчилгаа
 - Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны дүрэм
 - НҮБ-ийн зөвлөмж
- d) Олон улсын зөвлөмжийг Монгол Улсад хэрэгжүүлэх тухай болон тэдгээрийн харилцан хамаарал
- e) Эрх зүйн зохицуулалтын агуулга
 - Нэр томъёо
 - Хамрах хүрээ
 - Хязгаарлалт
- f) Аюултай барааны ангилал болон бүлэг
 - Ангиллуудын тодорхойлолт
 - Савлалтын бүлэг
 - Ангилал
 - Аюултай барааг таних
 - Аюултай барааны жагсаалт
 - Аюултай барааны жагсаалтыг ашиглах
 - Нэг төрлийн аюул учруулах чадвартай холимог болон уусмал бодис
 - Хэд хэдэн төрлийн аюул учруулах чадвартай холимог болон уусмал бодис
- g) Баглаж бооход тавигдах шаардлага
 - НҮБ-ын дугаартай баглаа боодол
 - Хязгаарлагдмал тоо хэмжээтэй аюултай барааны баглаа боодол
 - Хэмжээ тогтоогдоогүй баглаа боодлыг хэрхэн хийх
 - Аюултай бараа бүхий илгээмжийн баглаа боодлыг шалгах
 - Баглаа боодлын техникийн тэмдэглэгээ
 - Хэд хэдэн Аюултай бараа бүхий нэг баглаа боодол
 - Гадуур баглаа боодол
- h) Шошго, тэмдэглэгээ хийх тавих
 - Тэмдэг тавих ерөнхий шаардлага
 - Шошго зүүх ерөнхий шаардлага
 - Гадуур баглаа боодол

- i) Баримт бичгийн бүрдүүлэлт
 - Аюултай бараа илгээгчийн мэдүүлэг
 - Ачааны дагалдах хуудас
- j) Цацраг идэвхит материал
 - Хэмжих нэгж
 - Цацраг идэвхит материалын тодорхойлолт
 - Баглаа боодлын төрөл
 - Тоо ширхэгийн хязгаарлалт – “А” төрлийн баглаа боодол
 - Цацраг идэвхит материал бүхий зөвшөөрөгдсөн баглаа боодол
 - Тээврийн индекс
 - Шошго, тэмдэглэгээ хийх
 - Баримт бичгийн бүрдүүлэлт
- k) Улсын болон тээвэрлэгчийн зөрүү
 - Хүлээх үүрэг хариуцлага
 - Улсын зөрүү
 - Тээвэрлэгчийн зөрүү
 - Журам
- l) Ачааг шалгах журам
 - Хүлээн авах шалгах хуудас
 - Шалгаж хүлээн авах журам
- m) Зөвшөөрөгдсөн тоо хэмжээ
 - Зөвшөөрөгдөөгүй Аюултай барааны ангилал болон бүлэг
 - Баглаа боодлын тоо хэмжээний хязгаарлалт
 - Өөр өөр Аюултай барааг нэг баглаа боодолд хийх
 - Шошго зүүх
 - Ачааны дагалдах хуудас
- n) Аюултай бараатай холбоотой онцгой нөхцөлийн журам
 - Журам
 - Аюултай бараатай холбоотой онцгой нөхцөлийн үед авах арга хэмжээ

ХӨТӨЛБӨР 2 – Нисэх баг болон ачаалал төвлөрөлтийн ажилтнууд

- a) Ерөнхий мэдээлэл ба сургалтын танилцуулга
- b) Монгол Улсын хууль, дүрэм
- c) Олон улсын зөвлөмж
 - ICAO-гийн Техникийн зааварчилга
 - Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны дүрэм
- d) Аюултай бараа

- Нэр томъёо
- Хүлээж авах боломжтой Аюултай бараа
- Ямар ч тохиолдолд тээвэрлэхийг хориглосон аюултай бараа
- Тусгай зөвшөөрөлгүйгээр тээвэрлэхийг хориглосон аюултай бараа
- Шаардлагад хамаарахгүй аюултай бараа
- Хязгаарлагдмал хэмжээтэй аюултай бараа
- Улсын ба агаарын тээвэрлэгчийн зөрүү

e) Ангилал ба бүлэг

- Нэр томъёо
- Ангилал ба бүлгийн бүтэн жагсаалт
- Аюултай барааны жагсаалт
- Ангилал
- Аюултай барааны жагсаалт
- Аюултай барааны жагсаалтын хуваарилалт

f) Баглаж боох

- Баглаж боох ерөнхий шаардлага
- Баглаж боох арга
- Баглаа боодлын төрөл

g) Тэмдэг тавих

- Тэмдэг тавих шаардлага
- Баглаа боодлын үзүүлэлтийн тэмдэг
- Баглаа боодлыг хэрэглэх тухай тэмдэг тавих

h) Шошго зүүх

- Шошгонд тавигдах ерөнхий шаардлага
- Аюулыг илэрхийлсэн шошго
- Тээвэрлэлтийн шошго
- Аюултай бараа бүхий ачааны нэгж төхөөрөмжид шошго зүүх

i) Ачаалах ба хадгалах

- Аюултай барааны баглаа боодлыг шалгах
- Аюултай барааны баглаа боодлын аюулгүй байдлыг хангах

- Нисэх багийн бүхээг болон зорчигчийн агаарын хөлөгт ачаалах хязгаарлалт
- Ачааны агаарын хөлөгт ачаалах
- Хоорондоо үл нийцэх аюултай барааг ачаалах
- Шингэн аюултай бараа бүхий баглаа боодлыг ачаалах
- Хортой болон халдвартай бодисыг ачаалах
- Цацраг идэвхит материалыг ачаалах
- Соронзон чанартай материалыг ачаалах
- Хуурай мөсийг ачаалах
- Өөрөө хийлэгддэг аврах завь, агаарын хөлгийн ослын үед хэрэглэх аврах иж бүрдэл, агаарын хөлгөөс ослын үед нүүлгэн шилжүүлэх гулсуур
- Амьд амьтдыг аюултай бараатай хамт ачаалах
- Тэлэх чанартай нийлэг эдээр хийсэн зүйлийг ачаалах
- Зай хураагуураар тэжээлээр хөдөлж явдаг тэргэнцэр болон бусад хэрэгслийг ачаалах

j) Мэдээлэх журам

- Хөлгийн даргад өгөх мэдээлэл
- Нислэг дэх онцгой нөхцөлийн үед хөлгийн даргаас өгөх мэдээлэл

k) Аюултай бараатай холбоотой онцгой нөхцөлийн үед авах арга хэмжээ

- Журам

ХӨТӨЛБӨР 3 – Зорчигч үйлчилгээний ажилтан ба бүхээгийн ажилтан

a) Ерөнхий мэдээлэл ба сургалтын танилцуулга

b) Монгол Улсын хууль дүрэм

c) Олон улсын зөвлөмж

- ICAO-гийн Техникийн зааварчилгаа
- Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны дүрэм

d) Аюултай бараа

- Нэр томъёо
- Хүлээж авах боломжтой аюултай бараа
- Ямар ч тохиолдолд тээвэрлэхийг хориглосон аюултай бараа
- Тусгай зөвшөөрөлгүйгээр тээвэрлэхийг хориглосон аюултай бараа
- Зөвшөөрөгдсөн аюултай бараа
- Зөвшөөрөгдөх тоо хэмжээг нь тогтоож өгсөн аюултай бараа

e) Ангилал болон бүлэг

- Нэр томъёо
- Аюултай барааны ангилал, бүлгийн бүтэн жагсаалт

f) Нуугдмал Аюултай бараа

- Зорчигчийн тээшин дэх аюултай бараа
- Тусгай баглаа боодол шаардагдах зорчигчийн тээш
- Аюултай барааны тэмдэг эсхүл шошго, эсхүл хоёуланг зүүсэн тээш
- Зорчигчид өгөх мэдээлэл

g) Аюултай бараатай холбоотой онцгой нөхцөлийн үед авах арга хэмжээ

- Журам

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР 4 – Аюултай барааг ачаалах ба хадгалах ажилтнууд

a) Ерөнхий мэдээлэл ба сургалтын танилцуулга

b) Монгол улсын хууль дүрэм

c) Олон улсын зөвлөмж

- ИCAO-гийн Техникийн зааварчилгаа
- Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны дүрэм

d) Аюултай бараа

- Нэр томъёо
- Хүлээж авах боломжтой аюултай бараа
- Ямар ч тохиолдол тээвэрлэхийг хориглосон аюултай бараа
- Тусгай зөвшөөрөлгүйгээр тээвэрлэхийг хориглосон аюултай бараа
- Зөвшөөрөгдсөн аюултай бараа
- Зөвшөөрөгдөх тоо хэмжээг нь тогтоож өгсөн аюултай бараа

e) Аюултай барааны ангилал болон бүлэг

- Нэр томъёо
- Ангилал болон бүлгийн бүтэн жагсаалт

f) Тэмдэглэгээ хийх ба шошго зүүх

- Тэмдэг тавих ерөнхий шаардлага
- Шошго зүүх ерөнхий шаардлага
- Аюултайг илтгэх шошго
- Тээвэрлэлтийн шошго
- Аюултай бараа бүхий ачааны нэгж төхөөрөмжид шошго зүүх

g) Шалгах

- Аюултай барааны баглаа боодлыг шалгах
- Баглаа боодол гэмтсэн, асгарч гоожсон үед ажиллах журам
- Онцгой байдлын үеийн зохицуулалт
- Онцгой нөхцөлийн журам

h) Хадгалах болон ачаалах

- Аюултай барааны баглаа боодлын аюулгүй байдлыг хангах

- Нисэх багийн бүхээг болон зорчигчийн агаарын хөлөгт ачаалах хязгаарлалт
- Ачааны агаарын хөлөгт ачаалах
- Хоорондоо үл нийцэх Аюултай барааг ачаалах журам
- Бүлэг 5.2-ын органик хэт исэл болон Бүлэг 4.1-ийн өөрөө урвалд орох бодис
- Шингэн Аюултай бараа бүхий баглаа боодлыг ачаалах
- Хортой болон халдвартай бодисыг ачаалах
- Цацраг идэвхит материалыг ачаалах
- Соронзон чанартай материалыг ачаалах
- Хуурай мөсийг ачаалах
- Өөрөө хийлэгддэг аврах завь, агаарын хөлгийн ослын үед хэрэглэх аврах иж бүрдэл, агаарын хөлгөөс ослын үед нүүлгэн шилжүүлэх гулсуур
- Амьд амьтдыг Аюултай бараатай хамт ачаалах
- Тэлэх чанартай нийлэг эдээр хийсэн зүйлийг ачаалах
- Зай хураагуурын тэжээлээр хөдөлж явдаг тэргэнцэр болон бусад хэрэгслийг ачаалах

i) Мэдээлэх журам

- Хөлгийн даргад өгөх мэдээлэл
- Аюултай бараатай холбогдон гарсан осол зөрчлийг мэдээлэх
- Мэдүүлээгүй Аюултай барааны талаар мэдэгдэх

Нэгээс илүү төрлийн ажил үүргийг гүйцэтгэх, эсхүл зөвхөн нэг ангилал, бүлгийн аюултай бараатай харьцах ажилтны хувьд өмнө хамрагдсан сургалт нь хангалтгүй болно. Сургалтын хөтөлбөрийг тухайн ажилтны ажил үүргийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулна. Жишээлбэл нисэх багийн гишүүн ачаа хүлээн авах ажилтны үүргийг гүйцэтгэж байгаа ба нисэх багийн гишүүнд зориулсан сургалтын хөтөлбөрөөр сургалтад хамрагдсан байвал энэ нь ачаа хүлээн авах ажилтны хамрагдах ёстой сургалтын сэдвүүдийг бүрэн хамарч чадахгүй гэсэн үг юм.

Өөр нэг жишээг дурдвал Аюултай барааны нэг ангилал, эсхүл бүлэгт багтах будгийг үйлдвэрлэдэг байгууллагын хувьд тухайн будгийг агаараар тээвэрлэхэд баглаж боох, тэмдэглэгээ хийх, шошго зүүх болон бусад холбогдох шаардлагыг хангасан байх шаардлагатай.

3. Давтан сургалт

Аюултай барааны сургалтад хамрагдах шаардлагатай бүх ажилтны давтан сургалт хоорондын хугацаа 2 жилээс ихгүй байх шаардлагатай. Давтан сургалтын зорилго нь ажил үүргийнхээ дагуу сүүлчийн сургалтаар олж авсан мэдлэгээ сэргээх, шинээр гарсан өөрчлөлтийг судлахад оршино. Хэрэв боломжтой бол давтан сургалтыг явуулахаас өмнө аюултай барааны одоогийн мэдлэгт үнэлэлт дүгнэлт өгөх нь зүйтэй.

Үнэлэлт дүгнэлтийн үр дүнд дараагийн сургалтын цар хүрээг тодорхойлж, өмнөх сургалтын сэдвийг давтан үзэх шаардлагатай эсэхийг тодорхой болгох магадлалтай. Хэрэв өмнөх сургалтаар олж авсан мэдлэг боломжийн түвшинд байна гэж үзвэл тэдгээр сэдэвт харьцангуй бага цаг зарцуулж болно.

Анхан шатны сургалтыг явуулахын хувьд, мэдлэг болон ур чадварт үнэлэлт дүгнэлт хийх нь зүйтэй.

4. Аюултай барааны сургалтад хамрагдсан баталгаа

Сургалтад хамрагдсан этгээд бүрд нотлох баримтыг олгох нь зүйтэй. Нотлох баримтад сургалтын үеэр олж авсан мэдлэгийн түвшин, эсхүл мэдлэгт үнэлэлт дүгнэлт хийсэн дүнг тэмдэглэнэ.

Бие даан суралцсан тохиолдолд, мэдлэгийн түвшинг тодорхойлох, үр дүнг үнэлж дүгнэх журамтай байх нь зүйтэй.

5. Сургалтын бүртгэл

Сургалтын бүртгэлийг сургалтад хамрагдсан этгээдийн давтан сургалт зохих шаардлагын дагуу төлөвлөгдөж, 2 жилийн хугацаандаа явагдсан эсэхийг тодорхойлох зорилгоор хөтлөх шаардлагатай.

Сургалтад хамрагдсан хүн тус бүрийн хувийн хэрэгт дараах мэдээллийг тэмдэглэнэ:

- анхан болон хамгийн сүүлийн давтан сургалтын хөтөлбөр;
- хэзээ сургалтад хамрагдсан хугацаа;
- сургалтыг зохион байгуулсан этгээд болон байгууллагын мэдээлэл;
- олж авсан мэдлэгийг баталгаажуулсан дүн.